



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ**

2014 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 222

Мандалговь


Хөрөнгө худалдах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль”-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 22 тоот тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасахад баримтлах журам”-ын 3.1.6, 3.2.6.а дугаар заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Цагаандэлгэр сумын ЭМТ-ийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 14'060'000 /арван дөрвөн сая жаран мянга/төгрөгийн анхны өртөгтэй, элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн 38-81 дуа улсын дугаартай УАЗ-469 маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 2'000'000 /хоёр сая/ төгрөгөөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн албаны дарга П. Очирбатад үүрэг болгосугай.

3. Худалдсан эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн дагуу данс бүртгэлээс хасахыг Цагаандэлгэр сумын ЭМТ-ийн дарга Н.Алтанцэцэгт даалгасугай.

ДАРГА  СБУДЖАВ